

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

№ 25/50

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн АХ-25/09 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг бүхэлд нь нийт 2,626,057,102 (хоёр тэрбум зургаан зуун хорин зургаан сая тавин долоон мянга нэг зуун хоёр) төгрөгөөр худалдан авахаар шийдвэрлэсүгэй.
2. “АНД Системс” ХХК-тай байгуулах “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцлүүдийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдан авахад шаардагдах аливаа хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг гаргах, баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



О.БОЛДБААТАР